



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2019.06.24-06.28

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээл дээр томоохон хоёр нэгдэл болов. Казино, зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Eldorado Resorts" компани адил чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Caesars Entertainment" компанийг 17 тэрбум ам.доллараар худалдан авахаар болжээ. Ингэснээр "Eldorado Resorts" компани нь АНУ-ын мөрийтэй тоглоомын хамгийн том компани болох юм. Мөн эм үйлдвэрлэгч "AbbVie" компани өөрийн өрсөлдөгч болох "Allergan" компанийг 63 тэрбум ам.доллараар худалдан авахаар тохиролцсон байна.

АНУ, Иран улс хоорондын харилцаа хурцдаж, газрын тосны үнэ энэ сарын хамгийн дээд цэгтээ хүрлээ.

Баасан гарагт "Их 20"-ийн орнуудын 14 дэх удаагийн чуулган эхэлж байгаатай холбоотойгоор АНУ БНХАУ-ын талаас ямар нэг нэмэлт нөхцөл хүлээж авахгүй, чуулган уулзалтаар худалдааны хэлэлцээрт хүрэх магадлал бага гэж АНУ-ын Засгийн газрын төлөөлөгч мэдээлсэн байна. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ. Харин удалгүй АНУ-ын Ерөнхийлөгчийн засаг захиргаа энэ удаагийн уулзалт өнгөрсөн сард зогссон худалдааны хэлэлцээг урагшлуулах зорилготой гэсэн тайлбарыг өгснөөр хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэв.

5-р сард АНУ-ын аж үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд огцом буурсан бол иргэдийн хувийн хэрэглээ болоод орлого нэмэгдсэн үзүүлэлттэй байв. Энэ долоо хоногт ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо бага зэрэг нэмэгджээ.

Европ: "Их 20"-ийн орнуудын чуулга уулзалтын үеэр АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан намжиж, Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөлттэй хаагдлаа.

Европын бүсийн эдийн засгийн өсөлт удааширч байгаатай холбоотойгоор ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж -0.34% болж буурав. 6-р сард Европын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд сүүлийн 3 жилийн доод түвшинд хүрчээ.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй тогтвортой байлаа.

"Их 20"-ийн орнуудын 14 дэх удаагийн чуулган Японы Осака хотод эхэлж байгаатай холбоотойноор Японы Ерөнхий сайд Шинзо Абэ чуулганыг нээж, "Чөлөөт худалдаа нь энх тайван, хөгжил цэцэглэлтийн суурь" гэж мэдэгджээ. Ингэхдээ "Протекционист бодлогоор хариу арга хэмжээ авах механизм нь үр ашиг багатай" гэж анхаарууллаа.

5-р сард Японы суурь инфляцийн түвшин буурчээ. Ингэснээр 6-р сард тус улсын аж үйлдвэрлэлийн салбар унах хүлээлттэй байна. Японы засгийн газрын мэдээлснээр 5-р сард суурь инфляци өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8%-аар өсжээ.

БНХАУ: БНХАУ-аас АНУ-д экспортолсон газрын ховор элементийн хэмжээ 5-р сард буурч, сүүлийн гурван сарын доод түвшинд хүрсэн байна.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,785.21	5.26% ▲
Dow Jones	АНУ	26,599.96	-0.45% ▼
S&P 500	АНУ	2,941.76	-0.29% ▼
Nasdaq	АНУ	8,006.24	-0.32% ▼
S&P/TSX	Канад	16,382.20	-0.87% ▼
FTSE 100	Их Британи	7,425.63	0.24% ▲
S&P/ASX 200	Австрали	6,618.80	-0.48% ▼
Nikkei 225	Япон	21,275.92	0.08% ▲
Hang Seng	Хонг Конг	28,542.62	0.24% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.40
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.12
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.17
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.34
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.94
DBM' 2023	USD	7.250%	105.00
TDBM' 2020	USD	9.375%	103.80

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.400	0.00
Libor 3M	2.320	-0.02 ▼
Libor 6M	2.200	-0.02 ▼
Libor 1YR	2.178	-0.02 ▼
US 2YR Bond	1.773	0.00
US 3YR Bond	1.725	0.00
US 5YR Bond	1.776	-0.01 ▼
US 10YR Bond	2.014	-0.04 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.06.28	Өөрчлөлт
USD	2,657.76	0.03% ▲
CNY	387.03	0.17% ▲
EUR	3,026.39	0.69% ▲
RUB	42.13	0.07% ▲
KRW	2.30	0.88% ▲
JPY	24.69	-0.16% ▼
CAD	2,029.91	0.74% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,409.55	0.71% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.32	-0.21% ▼
Зэс	USD/lb.	271.35	0.35% ▲
Нүүрс	USD/MT	68.83	-4.56% ▼
WTI газрын тос	USD/bbl.	58.47	1.81% ▲
Brent газрын тос	USD/bbl.	66.55	2.07% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.31	5.48% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. V	11.03%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. V	11.60%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. V	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. V	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. V	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 47 компанийн 1,117.6 сая төгрөгийн 6,328,649 ширхэг хувьцаа арилжигдав.

“МИК Холдинг” /MIK/ компанийн хувьцаа 36.79%-аар буюу хамгийн ихээр өсөж 14,500.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Нийслэл өргөө” /NUR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 5,015.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


6-р сарын 28-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,601.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,785.21 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 5.26%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,117.6
Зах зээлийн үнэлгээ	2,601,660.7

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,785.21	5.26% ▲
MSE I индекс	9,743.03	10.65% ▲
MSE II индекс	8,116.71	1.58% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард даатгал	463,783	321,118,461
Ард кредит ББСБ	3,179,348	254,684,093
Монгол шуудан	176,587	109,194,897
Монос хүнс	880,703	62,431,933
Түмэн шувуут	323,447	60,784,539

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
МИК Холдинг	14,500.00	36.79% ▲
Э-транс ложистикс	132.25	32.25% ▲
Хүннү менежмент	281.35	32.24% ▲
Шивээ овоо	2,104.00	23.69% ▲
Монгол шуудан	691.16	15.58% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нийслэл өргөө	5,015.00	-15.00% ▼
Силикат	90.00	-14.29% ▼
Ариг гал	3,200.00	-11.11% ▼
Ремикон	27.00	-9.70% ▼
Могойн гол	6,600.00	-5.71% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	640,308,117
Бумбат-Алтай	292,846,987
Гаули	218,221,815
Голомт Капитал	217,841,597
Стандарт инвестмент	217,565,886

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	582.83	620,237
Таван толгой	7,385.00	388,933
Говь	14,500.00	300,285
МИК Холдинг	294.31	229,595
Инвескор ББСБ	1,802.00	129,254

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үр дүнг танилцууллаа

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 6-р сарын 20-нд Нова Скошиа мужийн Халифакс хотод зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үр дүнг танилцуулсан байна. Хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох, аудиторыг дахин томилох, хуваарилагдаагүй опционыг батлах, ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.

1. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хувьцаа эзэмшигчид Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн гишүүдийн төлөө санал өгч, сонгосон.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дараа ТУЗ нь дараах удирдлагын багийг томилов. Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал – Петер Акерли, ТУЗ-ийн дарга – Т.Лэйтон Крофт, Санхүү хариуцсан захирал – Роберт Женкинс, Компанийн нарийн бичгийн дарга – Сюзан Фрэйз нар томилогдлоо.

2. Аудиторыг дахин томилох

Компанийн аудиторор Кэй Пи Эм Жи ХХН (“KPMG LLP”) компанийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал, эсвэл өөр компанийг томилох хүртэл дахин сонгож, ТУЗ-д аудиторын цалин урамшууллыг тогтоох эрхийг олголоо.

3. Хуваарилагдаагүй опционыг батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Торонтогийн Хөрөнгийн Биржийн дүрэм журмын дагуу Компанийн 10%- ийн хуваарилагдаагүй опционы урамшууллын хөтөлбөрийн дагуу олгогдвол зохих бүх хуваарилагдаагүй опционыг батлахыг хувьцаа эзэмшигчид зөвшөөрөв.

4. Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах

Хувьцаа эзэмшигчид Компанийн ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. Энэхүү ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн Удирдлагын мэдээллийн танилцуулга, мөн www.sedar.com дахь компанийн хуудсаас танилцах боломжтой.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Монгол базальт” ХК болон “Машин механизм” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Монгол базальт” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгө (татварын дараа) тараасныг 2019 оны 06 дугаар сарын 24-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

“Машин механизм” ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах зорилгоор ногдол хувь болох нэгж хувьцаанд 1,100 төгрөг (татварын дараа) тараасныг 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

“Хүннү менежмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Хүннү Менежмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 20-ны өдрийн № 6/01 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 8-р сарын 05-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2019 оны 8-р сарын 05-ны өдрийн 14:00 цагт

Хуралдах газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж Рокмон бьюлдинг оффис, 404 тоот

Бүртгэлийн өдөр: 2019 оны 7-р сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн баталж буйтай холбогдуулан 2019 сүүлийн хагас жилийн бизнес төлөвлөгөө батлах;
3. Компанийн дүрмийг өөрчлөн батлах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
5. Компанийн өрийг хувьцаанд шилжүүлэх төслийг хэлэлцэж батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл харилцдаг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж Рокмон булдинг оффис, 404 тоотод ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 9099-1991.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6-р сарын 07-ны өдрийн № А/20 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт

Хуралдах газар: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д

Бүртгэлийн өдөр: 2019 оны 7-р сарын 1-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
2. Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл харилцдаг үнэт цаасны компани болон Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, 14210, Худалдаа, хөгжлийн банкны төв байранд байрлах “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн байранд ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 7709-0077.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

6-р сарын 1-ний өдрөөс 26-ны өдрийг хүртэл хугацаанд 1.8 тонн алт худалдан авлаа

Монголбанк энэ оны эхнээс 6-р 26-ны өдрийг хүртэл хугацаанд 6 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 6.8 тонн үнэт металл худалдан авснаас 846 кг-аар бага буюу 12%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 6-р сарын 1-ний өдрөөс 6-р сарын 26-ны өдрийг хүртэл хугацаанд 1.8 тн үнэт металл худалдан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 168 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 84 кг үнэт металл худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 1.9 тн үнэт металл худалдан авч байснаас 95 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 6-р сарын 1-ний өдрөөс 6-р сарын 27-ны өдрийн байдлаар 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 115,086.05 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк



УУХҮЯ: Зэс төсөвт төвлөрүүлэх орлогоор тэргүүлэв

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас энэ оны эхний таван сарын статистик үзүүлэлтүүдийг мэдээллээ.

Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулсан татвар хураамж

Оны эхний тавдугаар сарын байдлаар улсын төсөвт 1.2 их наяд төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

1	Зэс	531.0 тэрбум төгрөг
2	Нүүрс	523.3 тэрбум төгрөг
3	Цайр	41.4 тэрбум төгрөг
4	Алт	15.8 тэрбум төгрөг
5	Жонш	13.5 тэрбум төгрөг
6	Төмөр	9.8 тэрбум төгрөг
7	Бусад	35.1 тэрбум төгрөг

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 318.2 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар өссөн байна. Үүнд:

1	Нүүрс	205.4 (64.4%) тэрбум төгрөг
2	Зэс	105.9 (24.9%) тэрбум төгрөг
3	Төмөр	1.2 (14.4%) тэрбум төгрөг
4	Жонш	7.1 (110.6%) тэрбум төгрөг
5	Бусад	6.0 (20.7%) тэрбум төгрөг

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1	Алт	5.0 (24.1%) тэрбум төгрөг
2	Цайр	2.1 (4.8%) тэрбум төгрөг

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

УУХҮЯ: 6-р сарын 12-ны байдлаар Монгол улс 2.84 сая баррель газрын тос экспортолсон

6-р сарын 12-ны байдлаар Монгол Улс 2.84 сая баррель газрын тос экспортолсон талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. 2019 онд нийт 8.15 сая баррелийг экспортолж, 223.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа юм.

Энэ дунд "PetroChina Dachin Tamsag" компани 95.5 хувийг, "Доншин" компани 4.5 хувийг экспортлох төлөвлөгөө батлуулсан байна. Олон улсын зах зээлд Иран, АНУ-ын харилцаа хурцадсан болон бусад хүчин зүйлсээс хамаараад Вэст Техас газрын тосны ханшсүүлийн 2 сард хувиар өсөөд байна. Монгол Улс Энэтхэгийн нэг тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлээр газрын тосны үйлдвэр байгуулахаар дэд бүтцийн ажлаа гүйцэтгэж байгаа юм. Төсөл дуусаж, үйлдвэр ашиглалтад орсны дараа түүхий эдийн хангамж тасалдах эрсдэлтэй гэж Монголын геофизикийн холбооны Гүйцэтгэх захирал Д.Цэдэнбалжир онцолж байв. Одоогоор "PetroChina Dachin Tamsag" компани нэмэлт хайгуул хийх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. Мөн "Petro Matad" компани энэ онд дөрвөн цооногт хайгуулын өрөмдлөг хийхээр төлөвлөж байна. "Монгол Улсын Засгийн газар газрын тосны хайгуулыг дэмжиж байгаа нь мэдрэгдэж байгаа" гэж "Petro Matad"-ийн Гүйцэтгэх захирал Майкл Бак онцоллоо.

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 6-р сард ОХУ-аас импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ тонн тутамдаа 25 ам.доллараар буурсан байна. Үүний нөлөөгөөр шатахууны жижиглэнгийн үнэ 50 орчим төгрөгөөр буурсан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ.

7-р сард нийлүүлэх шатахууны хилийн үнэ дахин ижил хэмжээгээр буурах хүлээлттэй байгаа юм. Тиймээс наадмын өмнөхөн шатахууны үнэ дахин ижил дүнгээр буурч магадгүй гэж Ашигт малтмал, Газрын тосны газар тооцоолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

5-р ОХУ-аас БНХАУ-д нийлүүлсэн нүүрсний хэмжээ өссөн ч Австрали, Монголынх буурлаа

БНХАУ ОХУ-аас импортлох нүүрсний хэмжээгээ нэмэгдүүлсэн бол Австрали, Монголоос авсан нүүрсний хэмжээ буурсан байна.

БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын мэдээллийг харвал тавдугаар сард ОХУ-аас авсан нүүрсний хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 64 хувиар өсөж, 3.93 сая тонн боллоо. Энэ дундаа 596 мянган тонн буюу 15 хувь нь коксжих нүүрс байжээ. Мөн хугацаанд БНХАУ-ын Индонез улсаас импортолсон нүүрсний хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 46 хувиар өсөж, 13.2 сая тонн болсон байна.

Мөн энэ нь 2019 он гарснаас хойших хамгийн өндөр дүнд тооцогдож байгаа аж. Эрчим хүчний нүүрсний нийлүүлэлтээр тэргүүлдэг Индонезийн тухайд Австралийн нүүрсний нийлүүлэлт 5.5 хувиар буурч, 5.25 сая тонн болжээ. Үүнээс 26 хувь буюу 1.38 сая тонныг нь коксжих нүүрс бүрдүүлсэн нь хоёрдугаар сараас хойших хамгийн бага дүн боллоо.

Харин Монголоос нийлүүлсэн нүүрсний хэмжээ 3.68 сая тонн болж, жилийн өмнөхөөс 8.9 хувиар буурсан бөгөөд 95.9 хувь буюу 3.53 сая тонн нь коксжих нүүрс байсан талаар БНХАУ-ын гаалийн мэдээлэлд дурджээ. БНХАУ-ын хувьд тавдугаар сард нийт 27.47 сая тонн нүүрс импортолж, энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 23 хувиар өссөн дүн болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Монголбанк: инфляци 2019 оны эцэст 7.2 хувь, 2020 оны эцэст 7.8 хувь байх төлөвтэй

Инфляци 2019 оны эцэст 7.2 хувь, 2020 оны эцэст 7.8 хувь байх төсөөллийг Монголбанк танилцууллаа. Энэ оны 5-р сарын байдлаар инфляци улсын хэмжээнд 7.9 хувь Улаанбаатар хотын хэмжээнд 8.8 хувь байна.

Улаанбаатарын инфляцид мах, шатахууны үнийн нөлөө нэмэгдсэнээр инфляцийн 45 хувь буюу дөрвөн нэгж хувийг гурван төрлийн бүтээгдэхүүн бүрдүүлжээ. Зургаадугаар сард шинээр гаргасан инфляцийн төлөв байдлын тайланд дурдсанаар төсөөллийг бууруулахад хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал, хэрэглээний зээлийн жилийн өсөлт саарч, оны эхнээс зээлийн үлдэгдэл буурч байгаа нь ханшийн сулрах дарамтыг бууруулахын зэрэгцээ цалингийн өсөлтийн инфляцийг нэмэгдүүлэх нөлөөг сааруулж байна гэжээ.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын зардлууд хойшилж, төгрөгийн ханш БНХАУ-ын юанийн эсрэг чангарсан нь нөлөөлсөн байна. Харин төсвийн хөрөнгийн зардлын өсөлт, түүний дам нөлөө нь цаашид буюу 2020 онд инфляцийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Хэдий тийм боловч нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө алгуур саарч, нийт инфляци төсөөллийн хугацаанд зорилтот түвшний орчимд хадгалагдахаар байна гэсэн байна.

Төсвийн төлөв сонгуулийн жилд хүлээлтээс давж суларвал эрэлтийн шинжтэй инфляцийн нэмэлт дарамтыг бий болгох эрсдэлтэй гэж үзсэн байна. Мөн "Худалдааны дайн"-аас үүдэж түүхий эдийн үнэ буурч, төгрөгийн ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэн импортын барааны үнийг өсгөх эрсдэлтэй гэж дүгнэжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Б.Даваадалай: Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг эрэмбэлбэл ахиц гарна

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл оны эхний таван сарын байдлаар 146.1 тэрбум төгрөгийн ашигтай гараад байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өндөр, үнэ тогтвортой байсан сүүлийн хоёр жилийн мөн үед төсвийн тэнцэл ашигтай гарсан юм. Хэдий тийм боловч дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн огцом өөрчлөлтөөс шалтгаалсан "уналт-сэргэлт"-ийн мөчлөгийн нөлөөг бууруулах зохистой бодлого, эдийн засгийн төрөлжилт чухал гэж Дэлхийн банк онцолж байна.

Мөн тааламжтай үед хуримтлуулдаггүй, хүнд үед зарлагаа нэмэгдүүлдэг нь төсвийн хүндрэлийн гол асуудал болсоор байгааг анхааруулаад байгаа юм. Мөн төсвийн хөрөнгө оруулалтыг боловсрол, эрүүл мэндийн салбарт үр ашигтай чиглүүлэх нь ядуурлаас гарахад дэмжлэг болно гэж үзэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ОУВС-гийн ажлын хэсэг дүрмийн IV заалтын 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийж дуусгалаа

Олон улсын валютын сан (ОУВС)-ийн ажлын хэсэг 2019 оны 6-р сарын 19-өөс 28-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, ОУВС-гийн Дүрмийн IV заалтын дагуу хэрэгждэг 2019 оны зөвлөлдөх яриа хэлэлцээг хийлээ. Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд хэвлэлийн мэдээ гаргадаг бөгөөд энэ удаа дараах зүйлсийг онцолжээ. Үүнд:

1. Монгол Улс эдийн засгийнхаа эрсдэл даах чадварыг бэхжүүлэх чиглэлээр ихээхэн ахиц гаргалаа. Эрх баригчид эдийн засагт гарсан нааштай өөрчлөлтийг зохистой ашиглаж, засгийн газрын тодорхой өрийг барагдуулж, гадаад валютын нөөцийг сэргээн нэмэгдүүллээ.
2. Хэдий тийм ч эдийн засгийн буфер буюу хамгаалалт нь томоохон шокиг даван туулахад хүрэлцэхээргүй байна. Эдийн засаг гадаад орчны болон уур амьсгалын өөрчлөлтөд хэт мэдрэг хэвээр байна. Хэдийгээр эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаа ч ядуурлын түвшин өндөр хэвээр байна.
3. Эдийн засгийн буфер бий болгох, бүтцийн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх замаар өнөөг хүртэл хүрсэн үр дүнг өргөжүүлэх нь тэргүүлэх зорилт байх ёстой. Эдийн засгийн өсөлтийг тогтвортой, хүртээмжтэй, ногоон болгоход санхүүгийн секторын шинэчлэлийг хэрэгжүүлэх, засаглалыг сайжруулах, хөдөө аж ахуйн бодлогыг шинэ түвшинд гаргах нь чухал ач холбогдолтой.

"Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн дараагийн шатны санхүүжилт хойшилж байгаа гол шалтгаан нь арилжааны банкнуудын өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг нягтлах ажлын явц хүлээгдэж байгаатай холбоотой гэж Олон Улсын Валютын Сангийн Ажлын хэсгийн ахлагч Жэфф Готтлиб мэдэгдлээ.

Өөрөөр хэлбэл банкнууд өөрийн хөрөнгөө бодитоор нэмэгдүүлэхийн зэрэгцээ санхүүгийн эрсдэлээс жийргэвчлэх хэмжээнд нэмэгдүүлж чадсан эсэхэд гуравдагч хөндлөнгийн байгууллага саяхан аудит хийж эхэлсэн байна. Энэ ажил дууссаны дараа Олон Улсын Валютын Сангийн захирлуудын зөвлөлөөр хэлэлцэж, дараагийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой гэж мэдээлсэн юм. Харин төсвийн бодлогын тухайд зарлагын хяналтаас гадна төсвийн оновчтой хуваарилалт, бүтэц чухал байгааг онцоллоо.

Эх сурвалж: Монголбанк, BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.